



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан, нийт 66,080,000 (жаран зургаан сая наян мянга) төгрөгийн үнэ бүхий, хавсралтад заасан 4 тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг эзэмшигч байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.


3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



Нийслэлийн Засаг даргын 2023 оны
01.12.2023 сарын 16-ны өдрийн
..... захирамжийн
..... хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Марк	Арлын дугаар	Үйлдвэр- лэсэн он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Эзэмшигч байгууллагын нэр
1	Яаралтай тусламжийн автомашин	NISSAN NV-200	VM20-038453	2012	16,520,000	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	БЗД-ийн 4-р хорооны "Эрүүл өрх" ӨЭМТ
2	Яаралтай тусламжийн автомашин	NISSAN NV-200	VM20-040106	2012	16,520,000	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	БЗД-ийн 5-р хорооны "Хасагт Эрдэнэ" ӨЭМТ
3	Яаралтай тусламжийн автомашин	NISSAN NV-200	VM20-036313	2012	16,520,000	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	БЗД-ийн 8-р хорооны "Ачлахуй" ӨЭМТ
4	Яаралтай тусламжийн автомашин	NISSAN NV-200	VM20-007940	2012	16,520,000	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	БЗД-ийн 16-р хорооны "Насан-Урт" ӨЭМТ
Бүртгэх тээврийн хэрэгслийн дүн					66,080,000		